

1

МОНГОЛ УЛС: ШИЛЖИЛТИЙН ЭДИЙН ЗАСГААС “СОНГУУЛИЙН ЭДИЙН ЗАСАГТ”

Б.Батмөнх

Абстракт: Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэлд Монгол Улсын зах зээлийн эдийн засаг уруу хийсэн өнгөрсөн 20 жилийн шилжилтийн хүрсэн үр дүнд үнэлгээ өгч, алдаж оносноосоо сургамж авч, цаашдын анхаарах асуудлыг дэвшүүлэн тавихыг оролдсон. Ингэхдээ шилжилтийг хэрэгжүүлсэн “ цочир эмчилгээний” загварт шүүмжлэлтэй хандаж, Монголд хэрэгжүүлсэн “Вашингтоны тохиролцоо” хэмээх эдийн засгийн бодлогын шинэ загварын хэрэгжилтийн үр дүнг нухацтай судлахыг санал болгож, өнөөдөр Монгол Улсад “сонгуулийн” гэж нэрлэж болох эдийн засаг бүрэлдэн бий болсныг нотлон харуулсан.

1. Өнгөрсөн 20 жилийн хөгжлийн сургамжаас

Миний бие юуны өмнө аливаа шинэ ажлын эхлэл ямар байснаас дараагийн үе шат хамаардаг гэсэн логикоор өнгөрсөн 20 жилийн эдийн засгийн хөгжлийн үр дүнд хандлаа.

Аливаа улс орны хөгжлийн хувьд 20 жилийн хугацаа бол бага биш хугацаа юм. Үндэсний язгуур эрх ашгаа дээдэлсэн хөгжлийн загвартай, шудрага сайн засаглалтай улс орны хувьд бол 20 жилд хөгжлийн эрс өөрчлөлт хийж болдогийг 1960 он гэхэд нэг хүн амд ногдох орлого нь дөнгөж 70 гаруйхан ам доллар байсан, дайнд эдийн засаг нь сүйрсэн БНСУ –ын өндөр хөгжилд хүрсэн туршлага бэлээхэн харуулсан.

Ийм учраас Монгол Улсын өнгөрсөн 20 жилийн эдийн засгийн хөгжлийн хүрсэн түвшинд бид шүүмжлэлтэй хандаж, цаашид засаж залруулах зүйлд ихээхэн анхаарах учиртай.

Өнгөрсөн 20 жилд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг ямар загвараар, хэрхэн хийж ирснээс өнөөдрийн эдийн засгийн байдал ихээхэн хамааралтай байгаа юм.

Өнөөдрийн өндөрлөгөөс харахад 1990- ээд оноос эхэлсэн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг дэлхий даяар 2 үндсэн загвараар хийж иржээ. Энэ нь “цочир эмчилгээний” болон “ градуалист” буюу үе шатлалт гэсэн 2 загвар байв. Хуучин социалист гэгдэх орнууд болох Зүүн Европын орнууд, хуучин ЗХУ болон Монгол Улс цочир эмчилгээний загвараар шилжилтийг хийж ирсэн. Харин Хятад болон Вьетнам улсууд 2 дахь буюу үе шатлалт загвараар шилжилтийг хийж иржээ.

1990 – ээд оны үед Дэлхийн банк, ОУВС болон АНУ – ын санхүү, эдийн засгийн онолч, номлогчдын санаа бодлыг Жон Уильямсоноор удирдуулсан хэсэг эрдэмтэд, онолчид, зарим нөлөө бүхий улс төрчид оролцон нэгтгэж, одоо “ цочир эмчилгээ” гэж алдаршсан нэгэн жорыг хөгжиж байгаа болон хуучин социалист орнуудыг зах зээлийн эдийн засгийн харилцаанд хурдан шилжүүлэх зорилгоор бэлтгэсэн байдаг. Энэхүү эдийн засгийн бодлогын шинэ загвар түүхэнд “ Вашингтоны тохиролцоо” гэсэн нэрээр үлдсэн билээ. Энэхүү шинэ жорыг боловсруулах шаардлага нь шинэ өргөн уудам зах зээлийг өөрийн нөлөөндөө авах их гүрнүүдийн ашиг сонирхолтой нягт холбоотой байлаа. Энд 1970 –аад оноос эхэлж их гүрнүүдийн зүгээс хөгжиж байгаа орнуудад явуулсан шинэ колончлолын бодлого, түүнийг хэрэгжүүлж ирсэн “эдийн засгийн алуурчдын” урт гар ч Монголд хүрсэн байж болох магадлалтай. Үүнийг тусгайлан судлах шаардлагатай байна. Энэ нь миний энэхүү өгүүлэлд дэвшүүлж байгаа анхны шинэлэг санаа юм. Ийм санааг дэвшүүлэх болсон нь манай орны талаар судалсан гадаадын судлаачид, нэртэй эрдэмдтийн хэлсэн үгтэй зарим талаар холбоотой. ОУВС-ийн Монголд тулган явуулсан мөнгөний хатуу бодлого нь зээлийн өндөр хүүг бий болгосноороо дотоодын хөрөнгө оруулалтыг ашиглах ямарч боломжгүй болгож, Монголын аж үйлдвэрийг сүйрэлд оруулсан гэж манай орны тухай хэд хэдэн ном бичсэн Keith Griffin бичжээ.¹

“Ажилгүйдэл, ядуурал нь ОУВС-ийн гаднаас нь тухайн улсын төр, засгийг дарамталж, хилийн чанадаас хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн юм. Өнөөдөр аль нэг улс орныг атомын бөмбөгөөр бөмбөгдөн устгах хэрэггүй болжээ. Учир нь үүнээс илүү үр дүнтэй, хохирол багатай, илүү боловсронгуй колончлолын шинэ хэлбэр, эдийн засгийн технологийг олжээ. Өөрөөр хэлбэл, ОУВС, Дэлхийн банкиг энэхүү бодлогыг хэрэгжүүлэгч институт болгон хувиргажээ” гэж Нобелийн шагналт эдийн засагч Жозеф И.Стиглицт “Даяаршил ба түүний бухимдуулалт” номондоо дүгнэсэн байдаг.² Энэ бүхнээс харахад Монгол хэрэгжүүлсэн цочир эмчилгээний загвар дээрх зорилтод чиглэсэн ч байж болно.

¹ Keith Griffin, Poverty reduction in Mongolia, Asia Pacific Press, 2003

² Joseph E. Stiglitz, Globalization and its discontents. 2003.

Зарим эрдэмтэд анхнаасаа “цочир эмчилгээний” загварыг хэтэрхий эрсдэлтэй, ялангуяа нийгмийн салбарт хэтэрхий их гарз хохирол учруулах, урьдчилан харж болохооргүй олон муу үр дагавартай буруу арга гэж үзэж байсан. Энэ дүгнэлт Монгол Улсын туулж ирсэн 20 жилийн амьдралаас бэлээхэн харагдаж байгааг давтан нотлох шаардлагагүй билээ.


“Градуалист” буюу үе шатлалт загвар нь зах зээлийн эдийн засаг уруу үе шаттайгаар аажмаар шилжих стратеги бөгөөд өөрчлөлт, шинэчлэлтийг дэс дараатай, үе шаттайгаар, эхлээд тодорхой нутаг, дэвсгэр буюу салбарт туршилтын журмаар хэрэгжүүлж, үр дүнтэй нь практикт нотлогдвол улс орон даяар нийтэд нь хэрэгжүүлэхийг чухалчилдаг.

Энэ стратегийг баримтлагчид нэг удаагийн үнийн чөлөөлөлт болон богино хугацааны хувьчлалыг эсэргүүцдэг. Тэднийхээр өөрчлөлт, шинэчлэлт нь үйлдвэрлэлийн нэгэнт бий болсон потенциал, ажил эрхлэлтийн хүрсэн түвшинг эвдэх ёсгүй гэж үздэг. Ийм учраас энэ стратегийг хэрэгжүүлэхдээ үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тогтвортой хадгалахад гол анхаарлаа хандуулдаг. Энэ бол шилжилтийн хугацаанд ажилгүйдэл, ядуурлыг аль болон бага түвшинд байлгахад маш чухал арга болох нь Монгол Улсын өнөөгийн туулсан туршлагаас тодорхой харагдаж байна. Энэ загварыг хэрэгжүүлснээр үйлдвэрлэлийн хэмжээ тогтвортой хадгалагдаж, улмаар хэрэглээ, хуримтлал, хөрөнгө оруулалтын шаардлагатай нөөцийг тасралтгүй хангаж, хүн амыг аажмаар зах зээлийн шинэ нөхцөлд дасан зохицох боломжийг олгодог сайн талтай. Гэхдээ шилжилтийг эхлэх үед Монгол Улсад ийм загвараар шилжилтийг толгой мэдэн хийх нөхцөл, бие даасан шийдвэр гаргах боломж байгаагүй гэдгийг бид мэднэ. Энд шилжилтийн загварыг сонгохдоо Монгол Улсын газар зүйн байрлал голлох үүрэг гүйцэтгээгүй, гол нь хуучин социалист системийн бүрэлдэхүүнд ЗХУ -тай болон зүүн Европын орнуудтай эдийн засгийн хувьд нэлээд өргөн интеграцад орсон байсан нь илүүтэй нөлөө үзүүлсэн гэж үзэж байна. Нөгөө талаасаа Дэлхийн банкны зүгээс 1990 оноос ноён Саксын аргачлалаар энэ загварыг илүү сурталчилж хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байсан нь нөлөөлсөн.

Одоо өнгөрсөн 20 жилд “ цочир эмчилгээний загвараар шилжилтийг хэрэгжүүлсний эцсийн үр дүнг зарим гол үзүүлэлтээр авч үзье. Эдийн засгийн өсөлт, хүн амын амьжиргааны түвшинг нэгтгэн харуулсан гол үзүүлэлт болох нэг хүн амд ногдох ДНБ-ний түвшингээс харахад Монгол Улс 1990 оны түвшиндээ дөнгөж л 2007 онд хүрч, бүхэл бүтэн 17 жилийг зарцуулжээ.

Зураг№1

Дэлхийн банкны Атласын аргаар тооцсон нэг хүн амд ногдох ДНБ, ам. доллар




Эх сурвалж: Keith Griffin, Poverty reduction in Mongolia, Asia Pacific Press, 2003, Үндэсний Статистикийн Хорооны тоо мэдээлэл

Энэ үзүүлэлтийг хөгжлийн түвшин ойролцоо болон хуучин соцоалист системд байсан, шилжилтийг хамт хийж ирсэн улс орнуудтай жишиж Зураг -2 харуулав.

Зураг№2.


Шилжилтийн эдийн засагтай зарим орнуудын нэг хүн амд ногдох ҮНО,\$, 2009



Эх сурвалж: World Bank, World Development Indicators, 2010

Монгол Улс нэг хүн амд ногдох орлогоороо шилжилтийн орнууд дотроо сүүлдэж явна. Гэхдээ анхнаасаа эдгээр орнуудын сүүл барьж явсан тэр дүр зураг хэвээрээ үлджээ.

Харин Монгол Улс хүн амынхаа ядуурлын түвшингээр шилжилтийн эдийн засагтай орнууд дотроо эхний байруудад явна. Нэг хүнд ногдох орлого нэмэгдсэн боловч ядуурал буурахгүй байгаа Монголын эдийн засгийн хачирхалтай дүр зураг нь эдийн засгийн өсөлт нь ядуурлын бууралтанд шууд хүргэдэггүйг харуулав.



Эх сурвалж: World Bank, World Development Indicators, 2010

1990 оноос хойш Монголд нүүрлэсэн нийгмийн шийдвэрлэгдээгүй хурц асуудал нь хүн амын ядуурал билээ.


Хүснэгт №1. Хүн амын ядуурлын түвшин, хувиар

	Ядуурлын түвшин, %					
	1995	1998	2002-2003	2006	2007-2008	2009
Улсын дүн	36.3	35.6	36.1	32.2	35.2	38.7
хот	38.5	39.4	30.3	27.9	26.9	30.6
хөдөө	33.1	32.6	43.4	37.0	46.6	49.7

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны тоо мэдээлэл


Өнгөрсөн 15 жилд ядуурал хүн амын 32-38 хувийг эзэлсэн хэвээр огт буураагүй, харин ч 2009 онд буцаад нэмэгдсэн байна.

Монгол Улс хүн амын ажилгүйдлийн түвшингээрээ ч бас шилжилтийн орнууд дотроо хамгийн өндөр байгааг дараах зургаас харж болно.



Эх сурвалж: World Bank, World Development Indicators, 2010

Эцэст нь хүн амынхаа дундаж наслалтаар Монгол Улс хамгийн доогуур түвшинд яваа нь Зураг №6-аас харагдаж байна. (Эх сурвалж: World Bank, World Development Indicators, 2010)



Европын Сэргээн босголт, Хөгжлийн банкнаас 2006 онд шилжилтийн эдийн засагтай 29 орны зах зээлийн эдийн засаг руу хийж байгаа шилжилтийн үр дүнг үнэлж дүгнэхээр 9 гол үзүүлэлтээр харьцуулсан судалгааг хийжээ. Монгол Улс судалгаанд хамрагдсан 29 орноос 20 -р байранд буюу сүүлээсээ 9 дэх орон болжээ. Гайгүй үнэлгээ авсан 2 үзүүлэлт нь үнийн чөлөөлөлт, худалдаа болон валют солих тогтолцоо байв. Манай орон хамгийн муу үнэлгээг төрийн байгууллага, үйлдвэрийн

шинэчлэлт, өрсөлдөөний бодлого, дэд бүтэц, банк бус санхүүгийн байгууллага, аюулгүй зах зээлтэй холбоотой үзүүлэлтүүдээр авчээ. Саяханыг хүртэл Европын Холбоо Монгол Улсыг зах зээлийн эдийн засагтай орон гэж үзэхгүй байсаар ирсэн. Энэ бүхнээс харахад Монгол Улсын өнгөрсөн 20 жилийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үр дүн ямар байгаа нь тодорхой байна.

Гэхдээ өнгөрсөн 20 жилд үнэхээр ихээхэн өөрчлөлт, шинэчлэлт гарсныг үгүйсгэх бас аргагүй билээ. Эдийн засгийн хүрээнд юуны өмнө дотооддоо эдийн засагт хувийн хэвшил зонхилох байр суурьтай болж бэхжсэн. Монгол Улсад сүүлийн 20 жилийн хугацаанд хувийн сектор эдийн засгийн өсөлт, хөгжилтөд голлох үүргийг гүйцэтгэх болов. Хувийн сектор 1989 онд ДНБ-ний дөнгөж 3.3%-ийг үйлдвэрлэж байсан бол 2009 онд ДНБ –ний 70 % -г хувийн хэвшил гаргасан. Гэвч төрөөс хувийн секторыг төрөөс идэвхтэй дэмжсэн тодорхой бодлого үгүйлэгдэж байна. Монголын эдийн засаг нээлттэй болж, гадаад худалдааг чөлөөлж, дэлхийн эдийн засгийн харилцаанд илүү нээлттэй оролцдог болсон нь өөрчлөлтийн нэг онцлог байв. Өнгөрсөн хугацаанд ихэнх нэр төрлийн барааны үнийг чөлөөлснөөр үнэ, ханш эрэлт, нийлүүлэлтийн харьцаагаар тодорхойлогдох нөхцөл бүрдсэн зэргийг дурьдаж болно.

Гэтэл “үе шатлалт” загвараар шилжилтийг хэрэгжүүлсэн орнууд илүү үр дүнд хүрсэн байна. Үүнийг БНХАУ-д ядуурлыг эрс бууруулсан дараах мэдээлэл тод харуулдаг.

Хүснэгт №2. Хятадын ядуу хүн амын тоо, сая хүнээр

Он	Нийт хүн амын тоо	Өдөрт 1\$-оос бага орлоготой хүн амын тоо	Өдөрт 2\$-оос бага орлоготой хүн амын тоо
1990	1143	360.6	799.6
1993	1185	343.6	769.8
1996	1224	200.8	631.6
1998	1248	201.2	620.8
1999	1258	218.4	623.6
2000	1267	194.4	567.4
2001	1276	183.0	529.6
2002	1285	167.4	495.2
2003	1292	152.2	460.7
2004	1300	133.2	415.7

Эх үүсвэр: Shahing Yusuf and Kaori Nabeshima. “China’s Development Priorities”, 2007

Цочир эмчилгээнийхэн болон градуалистуудын хоорондын мэтгэлцээнд дийлэнх шилжилтийн орнууд эхний стратегийг дагасан учраас цочир эмчилгээний талд шийдэгдсэн байдаг. Үнэн хэрэг дээрээ Хятадын зах

зээлд шилжих “ үе шатлалт” стратеги нь Төв болон Зүүн Европын орнууд, хуучин ЗХУ –ын бүрэлдэхүүнд байсан орнууд, ОХУ болон Монгол Улсад хэрэгжүүлсэн “цочир эмчилгээний” загвараас хүрсэн үр дүнгээрээ хавьгүй илүү байгаа нь нэгэнт тодорхой болоод байгаа боловч их гүрнүүд, түүний эрх ашгийг илэрхийлдэг ОУВС болон Дэлхийн банк мөн л улс төр, үзэл суртлын учир шалтгаанаар түүнийг ил тод хүлээн зөвшөөрөхгүй л хэвээрээ байна.

Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн гэх онолын шүүмжлэгчид, тухайлбал, Nolan “шилжилтийн ортодокс”- д гүнзгий ангал гарлаа гэж үзэж байгаа бөгөөд энэ нь “Вашингтоны тохиролцоо” –оор тохирсон “цочир эмчилгээний” загвар нэгэнт үр дүн муутай болох нь олон улс орны жишээгээр батлагдсантай зарим талаар холбоотой.

2. Монгол Улс шилжилтийн эдийн засгаас “сонгуулийн” эдийн засагт

Монголын эдийн засаг бол хэт улстөржсөн, жам ёсоороо хөгжих нөхцөл муутай эдийн засаг болсон. Парламентийн болон орон нутгийн сонгууль манай эдийн засагт хүчтэй нөлөө үзүүлдэг болсоор удаж байна. Монголын эдийн засгийн хөгжлийн бодлого нь сонгуулиар гарч ирсэн нам, эрх баригчдын 4 жилийн хугацаатай бодлогоор тодорхойлогддог бөгөөд эдийн засгийн хөгжлийн урт хугацааны уламжилсан бодлого байдаггүй гэж хэлж болно. Сонгуулийн өмнөх жилээс эрх баригч намын сонгуулийн зардлыг хандивлах ажиллагаа идэвхжиж, улсын болон хувийн томоохон компаниуд намуудад хөрөнгө цуглуулж хандивладаг. “Эрдэнэт” үйлдвэрээс эхлээд улсын томоохон үйлдвэрүүд, гаалийн байгууллага хүртэл (Үүний нотолгоо нь гаалийн дарга асан Баатарын хэрэг) намд тэрбумаар нь мөнгө олж өгдөг практик газар авсан. Ер нь эдийн засагт сонгуультай холбоотой мөнгөний эргэлт их болжээ.

Улс төрийн намууд нь засгийн эрхэнд гарахын тулд сонгогчдод эдийн засгийн хэр хэмжээнээсээ хэтэрсэн амлалт өгч гарч ирдэг. Намуудын сонгуулийн амлалт нь буцаад эдийн засагтаа маш хүчтэй дарамт үзүүлдэг болсон. Улс төрийн намууд сонгуулийн амлалтаа хэрэгжүүлэхийн төлөө эдийн засгаа золиослоход бэлэн гэдгээ тод томруун харуулсаар ирсэн. 2010 оноос хүн амд бэлэн мөнгө тарааснаар инфляци газар авч, 2010 онд 13 хувь өсч, ирэх онуудад хүчтэй нөлөөлөх макро эдийн засгийн тогтворгүй байдал үүсээд байна.

Төрийн эдийн засгийн бодлого нь маш муу байсны нотолгоо нь Монгол Улсад сүүлийн 4 жилд инфляцийн түвшин хамгийн хурдтай өссөн явдал юм.

Хүснэгт№ 3. Шилжилтийн эдийн засагтай орнуудын хэрэглээний үнийн индекс, жилийн дундаж хувь

	2005	2006	2007	2008	2009	2009/2004,%
Армени	0	2.9	4.4	8.9	3.4	120.9
Азербайжан	9.7	8.4	16.6	20.8	1.4	169.8
Беларус	10.3	7	8.4	14.8	12.9	165.8
Болгар	5	7.3	8.4	12.3	2.8	141
Хятад	1.8	1.5	4.8	5.9	-0.7	113.9
Чех	1.8	2.5	2.9	6.4	1	114.2
Эстон	4.1	4.4	6.6	10.4	-0.1	127.8
Гүрж	8.3	9.2	9.2	10	1.7	144.4
Унгар	3.6	3.9	7.9	6.1	4.2	128.4
Казакстан	7.6	8.6	10.8	17.2	7.3	162.8
Киргиз	4.4	5.6	10.2	24.5	6.9	161.7
Латви	6.7	6.5	10.1	15.4	3.5	149.2
Монгол	12.7	5.1	9	25.1	6.3	171.7
Польш	2.1	1.1	2.4	4.3	3.8	114.4
Румын	9	6.6	4.8	7.8	5.6	138.6
ОХУ	12.7	9.7	9	14.1	11.7	171.7
Словак	2.7	4.5	2.8	4.6	1.6	117.2
Таджикстан	7.1	10	13.1	20.5	6.4	170.8
Украин	13.6	9.1	12.8	25.2	15.9	202.9
Вьетнам	8.3	7.4	8.3	23.1	7.1	166.1

Эх сурвалж: World Bank, World Development Indicators,2010

УИХ 2011 оны төсвийг 10 хувийн алдагдалтайгаар, 805 тэрбум төгрөгийг хүн амд тараахаар баталснаар Монгол Улсын эдийн засаг бүхэлдээ “сонгуулийн” эдийн засаг болсон.


ДНБ-нийхээ 10 хувийг хүн амдаа зүгээр тараадаг эдийн засагтай улс дэлхийд Монголоос өөр байхгүй байна. Үүгээрээ манай улс дэлхийд цоо шинэ өвөрмөц “сонгуулийн” гэж нэрлэж болохоор (Election driven Economy) эдийн засгийг цогцлуулаад байна. Дэлхийн банк, ОУВС манайд 2011 онд инфляцийн түвшинг 20 хувиар нэмэгдэнэ гэж үзсэн. Энэ нь дээрх хэмжээний бэлэн мөнгө тараахтай холбоотой юм.

Сонгуулийн эдийн засгийн өөр нэг шинж нь эдийн засагт төрийн оролцоо улам өсөж байгаа явдал юм. 2005 онд ДНБ-нд төсвийн зардал 27 % эзэлж байсан бол 2011 онд 52% болж өснө. Үр ашиггүй төрийн зардал улам л томорсоор байна.Төсвийн зардлын дотор өрх айлд очдог урсгал шилжүүлэг буюу нийгмийн халамжийн зардал улам нэмэгдсээр байна.

“Сонгуулийн” эдийн засгийн өөр нэг шинж нь хөрөнгө оруулалт хийх шийдвэр мөн л сонгуулийн амлалт, сонгогдсон тойргийн эрх ашигаар тодорхойлогдоод зах зээлийн нөхцөлд дэх эдийн засгийн үр ашиг гол

шалгуур байхаа аль хэдийнээ больсон явдал юм. 2010 онд 76 тэрбум төгрөг сонгуулийн тойргуудад гишүүдийн мэдлээр зарцуулагдсан. Монгол Улсад төр нь эдийн засгаа хэрхэн баллаж байгааг доорх загвараар харуулж болно.

Монгол дахь “сонгуулийн” эдийн засгийн загвар



Энэхүү загвараар төрийн эдийн засгийн бодлого, шийдвэр юуны өмнө улс төрийн намуудын сонгуулийн амлалтыг биелүүлэхэд чиглэгдсэн байгаа. Засгийн газар хэдийгээр бодлогоо тодорхойлж УИХ –д оруулдаг боловч, ялангуяа төсвийн хуваарилалт дээр сонгуулийн амлалт тэргүүн зэрэгт тавигддаг зарчим үйлчилж ирлээ. Ингээд төрийн төсөв, санхүүгийн бодлого нь бүхэлдээ сонгуулийн амлалтыг урьтал болгосон бодлого болж хувирсан. Ингээд УИХ жил бүрийн төсвийг хэлэлцэж батлахдаа дээрх зарчмаар сонгуулийн амлалтаа хэрэгжүүлэх төсвийг батлан гаргадаг. Сонгуулийн амлалтанд тохируулсан төсөв, санхүүгийн бодлого нь мөнгөний бодлогыг мөн үүнд захируулахад арга буюу хүргэдэг. Эндээс сангийн сайдын барьж УИХ –д оруулсан төсвийн төсөл УИХ- аас батлан гаргасан төсөв ихээхэн зөрүүтэй болдог. Нэгэнт сонгуулийн амлалтыг хэрэгжүүлэхэд зориулагдсан, бэлэн мөнгө тараах, нийгмийн хавтгайруулсан халамжийн шинжтэй төсөв маань эргээд Монгол банкыг инфляцийн хүнд дарамтад таарсан мөнгөний бодлого явуулахад хүссэн хүсээгүй хүргэдэг. Бэлэн мөнгөний тараалт нь урьд үзэгдээгүй инфляцийн хөрөгдөл үүсгэж, дунд хугацаанд макро түвшний тогтворгүй байдлыг үүсгэдэг. Эндээс мөнгөний хатуу бодлого, зээлийн хүүгийн өсөлт, зээлийн хязгаарлалт хийгдэж, бизнесийн тун таагүй орчин үргэлжилдэг. Ийм чөтгөрийн тойрог нь “сонгуулийн” гэгдэх өнөөгийн манай эдийн засгийн амьдралд бодитой үргэлжилсээр ирлээ.

Сүүлийн 2 жилд Монгол дахь “сонгуулийн” эдийн засаг уур уурхайн баялагаар халуурч эхэлсэн. Оюу толгойн ордыг гадаадынханд өгөхдөө ч зөвхөн сонгуулын амлалтаа хэрэгжүүлэх өнцгөөс нь харж, урьдчилгаа зээл авч бэлэн мөнгө тараасан. Одоо Таван толгойн ордыг мөн сонгуулийн амлалтыг хэрэгжүүлэхэд ашиглах гээд тендерийн

шалгаруулалт дээрээ ирээд байна. Институцчилал хөгжөөгүй, ашигт малтмалын болон бусад хууль нь боловсронгуй бус, гадныхны захиалгаар хийгдсэн, авилгал газар авсан өнөөгийн нөхцөлд хэдийнээ шинж тэмдэг нь илэрсэн Голланд өвчин цаашид улам газар авах өндөр магадлалтай байна.

3.Алдаа дутагдал, сөрөг үр дагавар, анхаарах асуудал

Монгол Улс “цочир эмчилгээний” загвараар өөрчлөлт, шинэчлэлтийг эхлээд даруй 20 жил өнгөрсөн боловч бидний байгуулаад байгаа өнөөгийн нийгэм маань бидний хүсэн хүлээж байсан үр дүнг хараахан өгөөгүй л байна. Хамгийн гол нь ажилгүйдэл, ядуурал нийгмийн тулгамдсан асуудал хэвээр байна. Монгол Улс үндсэн хуулиндаа зарлан тунхагласнаар бол хүнлэг ардчилсан нийгэм байгуулах ёстой.

Чөлөөт зах зээл цэцэглэн хөгжих гол нөхцөл болсон ардчилсан сайн засаглал одоо болтол бүрдээгүй, гол нь эдийн засаг, бизнес бүхэлдээ улс төрийн хүчтэй нөлөөнд байгаагаас эдийн засаг жам ёсоороо чөлөөт өрсөлдөөний үр дүнгээр хөгжих боломж нь хязгаарлагдмал байна.

Монгол Улсын эдийн засагт 1994 оноос хойш өсөлт гарсан боловч, нийгмийн салбарын хөгжилд ялангуяа хүн амын амьжиргаанд дорвитой өөрчлөлт гарч чадаагүйгээр үл барам хүн амын бодит орлого ихээхэн буурч, эрүүл мэнд, боловсролын салбарт өмнө нь олсон ололтууд саарч, ажилгүйдэл, гэмт хэрэг нэмэгдэн, ядуурал нийгмийн шийдвэрлэвэл зохих тулгамдсан бодит үзэгдэл болсон юм.

Өнгөрсөн 20 жилд Монгол Улсад аж үйлдвэргүйжүүлэх үйл явц үргэлжилж ирсэн. 1995 онд ДНБ-д 12% эзэлж байсан боловсруулах аж үйлдвэр 2009 онд дөнгөж 5.9% эзэлдэг болжээ. Энэ нь эдийн засгийг хэт нээлттэй болгосноос үндэсний аж үйлдвэр гадаадын хүчтэй өрсөлдөгчдийн өмнө сөхөрч, импортын хямд бүтээгдэхүүн дотоодын зах зээлийг дүүргэсэн, Голланд өвчин зарим талаар газар авсны шинж юм.

Манай эдийн засаг ердөө 7-8 нэрийн экспортын барааны дэлхийн зах зээлийн үнээс хамааралтай болсон. Зэсийн дэлхийн зах зээлийн үнэ Монгол Улсын төсвийг байнга тогтворгүйжүүлсээр ирсэн. Үүний улмаас төсвийн тогтвортой байдлын хуулийг баталсан боловч энэ парламент буусны дараа 2013 оноос л хэрэгжих төлөвтэй байна.

Өнгөрсөн 20 жилд эдийн засгийн бүтэц улам доройтсон. Бүтээмж багатай, эцсийн бүтээгдэхүүн гаргадаггүй “анхдагч” гэж нэрлэгддэг ХАА болон уул уурхайн олборлох салбар эдийн засагт 50 хувийг эзэлж байна. 1995 онд ДНБ-д 12% эзэлж байсан, нэмэгдэл өртөг өндөртэй боловсруулах аж үйлдвэр 2009 онд дөнгөж 5.9% эзэлдэг болсон.

Монголд бий болсон шилжилтийн үеийн холимог эдийн засаг маань монополийн дангаар ноёрхол газар авсан, шударга өрсөлдөөнийг зохих ёсоор нь өрнүүлэх нөхцөл боломж нь хаалттай байгаагаараа онцлог байна.

4.Санал, зөвлөмж

- Ер нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, эрсдэлийн талаар тусгай судалгааг хийхийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд санал болгож байна.
- Монголын эдийн засгийг “сонгуулийн” шинж төрхөөс нь салгаж, жам ёсны үндэсний эдийн засаг болгохын тулд эдийн засаг, бизнесийг бүхэлд нь улс төрийн хүчтэй нөлөөнөөс ангид байлгах, эдийн засаг жам ёсоороо чөлөөт өрсөлдөөний үр дүнгээр хөгжих боломж бүрдүүлэх хууль эрх зүйн шинэ орчинг бий болгох цаг болжээ.
- Үүний тулд улс төр, бизнесийн бүлэглэлүүдийн эрх ашиг давамгайлсан хөгжлийн өнөөгийн загвараас “Үндэсний язгуур эрх ашгаа дээдэлсэн” хөгжлийн загварт шилжих
- Улс орноо “үйлдвэржүүлэх” бодлогыг орчин үеийн арга барилаар тууштай хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Эдийн засгийн бүтцийг үр ашигтай болгох урт хугацааны стратеги боловсруулж хэрэгжүүлэх нь зайлшгүй байна.
- Эдийн засгийн эрчимтэй өсөлт нь зөвхөн зохистой хөдөлмөрөөр дамжин ядуурлыг бууруулдаг тул хүн амд бэлэн мөнгө тараах арга замаар бус, харин бүтээмж өндөртэй ажлын байр шинээр бий болгох замаар ядуурлаас гарах стратегид шилжихийг санал болгож байна.
- Төсвийг боловсруулах, хэлэлцэх явцад иргэний нийгмийн байгууллагууд идэвхтэй оролцож, Засгийн газраас төсвийн төслийг боловсруулсан байдал, УИХ- аас батлагдан гарсан төсөв Засгийн газрын оруулсан төсвөөс хэр зөрүүтэй батлагдсан талаар ил тод өргөн шүүмжлэл өрнүүлж, улс төр , бизнесийн бүлэглэлүүдийн эрх ашиг давамгайлсан эдийн засгийн бодлогыг сөрөн зогсох цаг болжээ.

Ашигласан ном, материалууд

- 1.Keith Griffin, Poverty reduction in Mongolia, Asia Pacific Press, 2003.
- 2.Joseph E. Stiglitz, “Даяаршил ба түүний бухимдуулалт”. 2003.
- 3.Shahing Yusuf and Kaori Nabeshima. “ China’s Development Priorities” , 2006
- 4.European Bank for Reconstruction and Development, Transation report,2006: Finance in transation.
- 5.Lavigne, M, The Economics of tranzation: from Socialist Economy to Market Economy, 1995. Macmillan Press. Ltd.
- 6.“From Plan to Maket. World Development Report 1996.” The World Bank
- 7.World Bank, World Development Indicators,2010
8. Nolan, Peter, “China,s Rise, Russi’s Fall: Economic and Planning in the Transation from Stalism, Macmillan.
- 9.Б.Батмөнх болон бусад “Шилжилтийн үеийн макро эдийн засгийн олон улсын нийтлэг асуудлууд” сэдэвт суурь судалгааны тайлан
- 10.Үндэсний Статистикийн Хорооны статистикийн эмхтгэлүүд